



МОНГОЛ УЛС
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

201 тоот, Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976)70533620, Факс: (976)70533604,
И-мэйл: info@omnogovi.gov.mn, Вэб сайт: www.omnogovi.gov.mn

2024. 04. 01 № 01/796
танай _____-ны № _____-т

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ
ҮЙЛДВЭРИЙН ЗАСАГЛАЛЫГ
САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН АЖЛЫН
АЛБАНД

ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн 2023 оны
тайланг хүргүүлж байна.

Хавсралт 4 хуудастай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ц. ДЭНЭЭДОРЖ

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын
01-ны өдрийн 01/79 тоот албан бичгийн хавсралт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН 2023 ОНЫ ТАЙЛАН

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Санхүү жилтийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Хувь
0	1	2	3	4	5	6	7
1.Судалгаа мэдээ тайлан гаргах ажлын хүрээнд							
1.1	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт, хөдөлгөөний мэдээллийг omnogovi.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүрд шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллах	-	Ашиглалтын 108 хайгуулын 50	-	Судалгааны ажил хийгдсэн байна.	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт, хөдөлгөөний мэдээллийг omnogovi.gov.mn цахим хуудсаар дамжуулан тухай бүрд шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллаж байна	100
1.2	в/ Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ бүрийг www.iltodgeree.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих	-	3 гэрээг мэдээллийн санд байршуулсан.	-	3	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу "Хур эрдэнэ баялаг" ХХК, "Терра энержи" ХХК, "Саус гоби сэндс" ХХК-иудтай Хамтран ажиллах 3 гэрээг байгуулж www.iltodgeree.mn сайтад байршуулан тус ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.	90
1.3	Засаг даргын тамгын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн г салбарын шинэ мэдээллээр хангах, холбогдох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	-	Сургалт зөвлөгөөнд хамрагдсан байдал	-	3	2023 онд салбарын чиглэлээр доорх сургалт, чуулга уулзалтад хамрагдаж ажилласан байна. Үүнд: 1. Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Монголын уул уурхайн үндэсний ассоциациас зохион байгуулсан "Mining week" арга хэмжээнд оролцсон. 2. ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн газрын төлөөлөгчидын айлчлал, УУХҮЯ болон ОУИТБС-ын баталгаажуулалтын 2023 оны тайланг дүгнэх хэлэлцүүлэг, дэд	100

						<p>зөвлөлийг чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдсан.</p> <p>2023 оны Олон улсын санхүүгийн корпорацын Хөгжлийн төлөө ил тод байдал хөтөлбөрөөс зохион байгуулах гэж буй "Уул уурхайн өгөгдөл, мэдээлэлтэй ажиллах нь" Өмнөговь аймгийн сургагч багшийг бэлтгэх сургалт</p>
1.4	<p>Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлого тухайн сум орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөллөө үзүүлж, үр ашгаа үзүүлж байгаа талаар болон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж байгаа аж ахуй нэгжүүдийг сурталчлах, тухайн жилийн эцэст дээрх орлогын үр өгөөжийг Өмнөговь аймгийн цахим хуудсаар мэдээллэх</p>	-	Дэмжлэгийн тоо	-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	<p>2023 онд Өмнөговь аймаг - "Эрдэнэс таван толгой" ХК-ийн хооронд байгуулсан 2023 оны "Хамтын ажиллагааны гэрээ"-ний хүрээнд орон нутгийн хөгжлийг дэмжих санд 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийг суулгасан.</p> <p>Уг хөрөнгө оруулалтаар доорх ажлуудыг хийж гүйцэтгэв:</p> <ol style="list-style-type: none"> 1. Цогтцэций сумын "Төв суурин газрын тоосжилтыг бууруулах зорилгоор сумын төвд хатуу хучилттай авто зам барих ажлыг "Цэлмэг зам" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, ажлын явц 95 хувийн гүйцэтгэлтэй, 2,798,226,045 төгрөг; 2. "Шинэ мянган айл" орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Цогтцэций суманд 16 айлын орон сууц худалдан авах гэрээ байгуулан "Их Онги" ХХК-тай 2,296,940,800 төгрөгийн санхүүжилтээр гэрээ байгуулан, ашиглалтад хүлээн авч, төрийн албан хаагчдыг журмын дагуу орон сууцаар хангасан;

						Мөн Өмнөговь аймаг- Өсөх зоос" ХХК-ийн хооронд байгуулсан 2023 оны "Хамтын ажиллагааны гэрээ"-ний хүрээнд 2023-2024 оны төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад Даланзадгад хотын "Даланзадгадын ДЦС-д 1*3 мВт хүчин чадал бүхий иж бүрдэл станцыг нийлүүлсэн. Уг ажлуудыг Өмнөговь аймгийн цахим хуудсанд нийтэд ил тод байдлаар нийтэлж нийтийн мэдээллэн ажиллаж байна.
2.Иргэдэд нээлттэй ил тод мэдээллэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх ажлын хүрээнд						
2.1	Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудаас уурхайн хөдөлмөр эрхлэлт, олборлолт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд, хөрс хуулалт, ус ашиглалт, худалдан авалтын мэдээллийг улирал бүрд авах	-	-	-	2 улирал	Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн аж ахуй нэгжүүдээс 2023 оны 3, 4 дүгээр улиралд холбогдох мэдээллүүдийг нэгтгэн ашигт малтмал газрын тосны газрын Говийн бүсийн төлөөлөгчийн газарт олон нийтэд нээлттэй ил тод мэдээллэн ажиллаж байна.
2.2	Ил тод хариуцлагатай уул уурхай Өмнөговь аймгаас 2 сарын аян г Өмнөговь аймгийн 6-н сумдад зохион байгуулах	ОНТ	6 сум	-	6 сумдад ажиллах	Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён, Даланзадгад, Ханхонгор, Цогтцэций, Ханбогд сумдад оролцогч талуудын ил тод, хариуцлагатай уул уурхайн талаарх стандарт, ерөнхий ойлголтыг сайжруулах, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах чиглэлээр чадавх бэхжүүлэх, уул уурхайн салбарын талаар үнэн бодит тоо мэдээллийг хаанаас олж авах, хэрхэн ашиглах талаар өгөгдлийн боловсролыг нэмэгдүүлэх, ил тод мэдээллийг ашиглан тус суманд үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудын талаар өгөгдөлд түшиглэсэн энгийн ойлгомжтой харилцааны

						бүтээгдэхүүнийг хөгжүүлж, орон нутгийн иргэд, оролцогч талуудад түгээх, уул уурхайн салбарын эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалд үзүүлж буй үр нөлөөг бодит мэдээлэлд тушиглэн хэлэлцэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой Ил тод хариуцлагатай уул уурхай-Өмнөговь аймгаас 2 сарын аяг 6 сумдад зохион байгуулж иргэдийг мэдээллээр хангаж ажиллаа.
2.3	ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах	-	-	-	2 удаа хуралдах	ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн хурлыг 2023 онд иргэдэд ил тод мэдээллийг хүргэх асуудлаар 2 удаа зохион байгуулж ажиллаа.
3.Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавх бэхжүүлэх ажлын хүрээнд						
3.1	Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиллах	-	Уул уурхайн аж ахуй нэгж байгууллагуудтай танилцах	-	Уул уурхайн аж ахуй нэгж байгууллагуудтай танилцсан байна	Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Ц.Дэнээдорж-оор ахлуулсан ажлын хэсэг 2023 онд Өмнөговь аймгийн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй 13 компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиллаа.

ТАЙЛАН БИЧСЭН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН *С.Тэмүүжин* С.ТЭМҮҮЖИН